



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Мандалговь

“Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний
чанарыг сайжруулах” жил болгон
зарлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.2.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай А/760 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийн шалтгаан нөхцөл, эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлж, жирэмсний хяналтыг сайжруулж, эхийн ноцтой хүндрэл, нярай болон хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилгоор 2024 оныг “Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” жил болгон зарласугай.

2. “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан, удирдлага зохион байгуулалтаар хангаж, биелэлт, үр дүнг тооцон ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга (Л.Ганбат), Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (Б.Саруулцэцэг), эмнэлэг, эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

3. “Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах” жилийн ажлын явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг эмнэлэг, эрүүл мэндийн төв, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд оруулан тооцож ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга (Ц.Энхсайхан), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Оюунчимэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Б.АЛТАНТӨГС

9034064 & 4816129119